

ЗӨВЛӨМЖ

1. Галзуу өвчний үеийн хяналт, сэргийлэлт

А/. Галзуугаас сэргийлэх арга хэмжээ:

1. Аймаг, орон нутагтаа тандалт судалгаа хийж, хот суурин дахь эзэнтэй нохойг бүртгэн гэрчилгээжүүлж, дархлаажуулах;

2. Эх уурхайг таслан зогсоох зорилгоор золбин нохой, муур устгах ажлыг зохион байгуулах;

3. Галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж, ноцуулсан, шүлсдүүлсэн хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг /шарханд анхны цэгцлэлт хийж савангаар угаах, иодын уусмал түрхэх, галзуугаас сэргийлэх вакцин, ийлдсийг эмчийн хяналтанд хийх ба зэрлэг амьтанд уруулж, ноцуулж, шүлсдүүлсэн үед галзуугийн эсрэг эмчилгээний ийлдсийг вакцинтай хавсарч хэрэглэх/ шуурхай үзүүлэх;

4. Хүн урж ноцсон эзэнтэй нохойг мал эмнэлгийн байгууллагад мэдэгдэж онош тодруулах, 10 өдөр уяж, уг амьтны зан төрхөд ажиглалт хийх ба өвчний шинж тэмдэг илэрвэл уг нохойг устгах арга хэмжээг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5. Хүн урж ноцсон, шүлсдсэн золбин нохой, зэрлэг үнэг, чоно, хярсныг алж устган лабораторийн шинжилгээнд хамруулах;

6. Галзуу өвчний сэжигтэй мал, амьтанд ажиглалт хийх хугацаанд тэдгээртэй харьцаж байгаа хүмүүс халад, хормогч, бээлий, нүдний шил хэрэглэх;

7. Галзуу өвчнөөс сэргийлэх талаар эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх.

Б/. Галзуугийн хүний өвчний тохиолдлын үед авах халдвар хамгааллын арга хэмжээ:

1. Мэдээлэх: Галзуугийн сэжигтэй мал амьтанд уруулж ноцуулсан, шүлсдүүлсэн тохиолдол бүрийг тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, БГХӨСҮ Төвд 24 цагийн дотор мэдээлнэ.

2. Галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж ноцуулсан, шүлсдүүлсэн тохиолдол болон галзуу өвчний эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн өвчтөнг халдвартын эмнэлэгт эмчилнэ.

3. Илрүүлэлт: Голомтонд тархварзүйн тандалт судалгаа хийж, халдварын эх уурхайг тогтоон, цаашид авах арга хэмжээний асуудлыг /хүн урж, ноцсон, самардсан, шүлсдсэн нохойг ажиглалтанд авах, уг амьтанд галзуу өвчний шинж тэмдэг илэрвэл алж устган онош тогтоох / шийдвэрлэнэ.

4. Халдваргүйтгэл:

а/. Шүлс болон шүлсээр бохирдсон зүйлийг хлорын шохой, 3%-ийн хлорамин, 0,1%-ийн жавелион, 2%-ийн Виркон, 3%-ийн устөрөгчийн хэт исэл зэрэг уусмалуудын аль нэгээр халдваргүйтгэнэ. Эмч, эмнэлгийн ажилтан нар шүлсээр халдвар дамжин тархахаас сэргийлж резинэн бээлий, хамгаалах өмсгөлтэй ажиллана.

б/. Гэр ахуйд болон галзуу өвчний шинж тэмдэгтэй мал, амьтны байр хэвтэр, бохирлогдсон өвс тэжээл, өтөг бууц, газрын хөрсөнд халдваргүйтгэл хийнэ.

в/. Галзуугаар үхсэн мал, амьтны сэгийг шатааж эсвэл халдваргүйтгэж устгана.

5. Хөл хорио: шаардлагагүй.

6. Хавьтлуудыг дархлаажуулах: Голомтод байгаа хүмүүст эрүүл мэндийн үзлэг хийж, тархвар судлалын холбогдолтой болох нь тогтоогдвол /арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан, ил шархтай үедээ галзуугийн сэжигтэй мал, амьтны болон өвчтөний шүлстэй харьцсан/ харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад хандан урьдчилан сэргийлэх вакцин, ийлдсийг зааврын дагуу тариулна.